

ТҮҮХ, ЭДИЙН ЗАСАГ

**1870 ОНД БАРУУН АЙМАГТ ГАРСАН
АРДЫН ХӨДӨЛГӨӨНИЙ ТУХАЙ
(Архивын материалаас)****Л. Лувсанчүлтэм.**

XIX зууны хоёрдугаар хагаст Ар Монголын баруун аймгуудаар ардын хөдөлгөөн гарсан билээ. Энэ хөдөлгөөн нь харц албат, хамжлагын ардуудаас хар шар феодалуудыг эсэргүүцсэн ангийн тэмцлийн шинжийг агуулсан байв. Ангит нийгмийн түүх бол ангиудын хоорондын тэмцлийн түүх мөн гэж марксизм-ленинизм сургадаг. Монгол оронд хаан, ван язгууртан ноёдын засаг төр дангаар ноёрхсон тэр үед монголын нийгмийн үндсэн анги нь ард, феодал хоёр байсан бөгөөд тэдний хооронд ангийн тэмцэл үргэлж явагдаж байжээ. Ялангуяа монголчууд манж гүрний колони байсан үед феодал ноёдын дарлал мөлжлөгөөс гадна Хятад худалдаачин-мөнгө хүүлэгчдийн мөлжлөг улам нэмэгдсэн тул ард олны гаслан зовлон, ядуурал хоосрол цаглашгүй их болж феодал ангийн эсрэг тэмцэл улам ихээр өрнөсөн бөгөөд үүнд ард олон дотоодын феодал ангитай тэмцэхдээ гадаадын колоничлогчдыг эсэргүүцсэн тэмцлийг бас хослон явуулж байв. Энэ талаар «Манжийг эсэргүүцсэн ардын хөдөлгөөний дотор 1870 оны үеэр баруун аймагт гарсан хөдөлгөөн онцгой суурь ззэлнэ»¹ гэж манай түүхчид тэмдэглэсэн байдаг.

Хөдөлгөөн гарсан шалтгаан нөхцөл нь: феодал ноёд болон хошууны түшмэд ард олныг дарлан зовоох нь хэтэрхий болсон, албат ардын биеэр ба хөрөнгөөр гүйцэтгэх олон зүйлийн албан үүрэг асар хүндэрсэн, мөлжимтгий худалдаачин-мөнгө хүүлэгч хятадад төлөх ард олны өр шир дааж давшгүй болсон, Хотонгийн бослогын үед² ард олны мал хөрөнгө сүрхий хэлмэгдсэн зэргээс болжээ.

Үүнд ард олон чухам хэрхэн яаж дарлагдан зовж байсны зарим жишээ нь: хошууны тамгийн газар³ нь засаг ноёнд үйлчлэхдээ өчүүхэн төдий осолдсон ардуудыг шууд баривчлан аваад гяндангийн⁴ мухарт хаяж байв. Тэр гяндан гэгч нь чухамдаа хүний амьдын там гэхэд болно. Гяндангийн байшингууд нь нойтон, чийг ихтэй, бузар буртаг, хог новш дүүрэн, салхи агаар ба нарны гэрэл орохгүй, битүү бөгчим бөгөөд нохой бөөс, бясаа мэтийн хорхой шавьж язганалдан хоригдлуудыг зулгаана. Хоригдлууд бол хоол ундгүй шахам ямагт өлсгөлөн байдаг ба бие нь бөөс хуурс, өт хорхойд идэгдэх, асар аймшигтай зовж байв.

¹ Ш. Нацагдорж Халхын хураангуй түүх. 237-р тал.

² Манжийг эсэргүүцсэн үй олон хотон ардын зэвсэгт бослогын зүүн жигүүр Монголд нэвтрэн ирж, арваад жил амбаны цэрэгтэй тулалдсан юм.

³ Хошууны захиргаа.

⁴ Ялтанг хорих шорон.

Тамгын газрын эрхийг атгасан түшмэд-туслагч, захирагч, мэйрэн, залан нар⁵ бол буруу зөвийг мэдэхгүй булуу улаан жинстэн⁶ гэж алдаршсан хүмүүс байсан бөгөөд тэдний ааш авир харгис хэрцгий, энэрэнгүй сэтгэл байхгүй, санаа зүрх нь хээр хэвтсэн бул чулуунаас хатуу тул хэрэгтэй ардаас өчиг мэдүүлэг авахын төлөө банз, шаахай, ташуураар балбаж зодох даруй унгас савхтай адил пажигнуулдаг байв. Иймд ямар ч гэмт хэрэг хийгээгүй атлаа тэсч чадахгүй болж өөртөө огт хамаагүй хэрэг хүлээж, амь насаа алдсан хүн аль олон байжээ. Ийм хүнд бэрх дарлалыг ард олон хүлцэн тэсвэрлэж чадахгүйд хүрээд тэдгээр дарлагдчыг эсэргүүцсэн хөдөлгөөн гарч байжээ. Түүний нэг нь 1870 оны (Бүрэнт засагчийн⁷ 9 оны) зун тэр үеийн Сайн ноёны аймгийн нэр бүхий 8 хошуунд гарсан ардын хөдөлгөөн мөн болой. Түүнд оролцогчдын олонхи нь хамжлагын ардууд бөгөөд хүүхэд цагаас хөгшрөх насаа хүртэл феодалуудад боол болж явсан хүмүүс юм.

Феодал, баячууд болон хятад худалдаачинг дайран довтлох хэрэгт оролцохгүй бол эр хүн биш болохоос айсан мэт идэр эрчүүд олноор дарвин хөдөлсөн ба бас ноёд, хятадад үйлчилж байсан зарц шивигчин хүртэл дарвиж оролцсон байнам. Хөдөлгөөнд оролцогчид юуны өмнө ашиг хонжоонд ховдог, худалдаачин хятадад он жил дараалан төлсөөр ирсэн өр төлбөрийн данс бичгийг урж тасдах буюу шатаан устгаж байв. Улсын архивын манж хэлний материалд энэ хөдөлгөөний тухай бичсэн нь

—1870 он зун анх удаа Сайн ноёны аймгийн Ёст засгийн хошууны залан хэмээх Дэмчиг санаа үүсгэж, тэргүүн удаа 73 хүн, хоёрдугаар удаа 50 хүн нийлэлдэж хотон маягаар хувцаслан буу жад, бороохой шийдэм барьж тэдний нутагт байсан Шин Шинда гэдэг пүүсийг хоёр дахин дайрч 800 илүү хонь, ямаа, 100 шахам боодол бүс бараа, цай зэргийг булаан аваад мөн пүүсний данс бичгийг шатаасан⁸.

—Мөн оны 6-р сард Сайн ноёны гол хошууны ард Цэдэв тэргүүлэн 17 хүн буу барьж, хар туг хийсгэн (Хотонгийн туг хар өнгөтэй байсан юм) 4 өрх тайж, түшмэл айлыг довтолж 8 морь булаасан.⁹

—8-р сард Ачит гүнгийн хошууны ногоон Соном нарын 14 ард зэвсэг хэрэглэж, 4 өрх чинээлэг айлаас морь, үхэр 16, элдсэн нэхий зэрэг юмыг олзлон авсан.¹⁰

9-р сард Заяын шавийн Рааш тэргүүтэй 18 хүн зэвсгээр сүрдүүлэн байж 6 өрх айлаас үхэр 7, морь гүү 9, эсгий, шар тос мэтийн юм булаасан.¹¹

—10-р сард Эрдэнэ бандидын харьяат Гэлэнхүү нарын 14 хүн мөн л хар туг, хиур барьж, ноёд баяд голдуу 24 өрх айл руу дараалан довтолж буу тавин хашгиралдаж, хүмүүсийг зодож жанчин морь, үхэр хонь, ямаа болон дээл хувцас булаан аваад гэр оронг түймэрдэн сүйтгэсэн ба бас Ван Дармын хошууны нутаг Тойрог чулуу гэдэг газар байсан Ши Хэгүн пүүсийг шөнийн харанхуйгаар дайрч бид хүн ална гэж өндөр дуугаар хашгиралдан буу тавин, чулуу шидэж худалдаачин нарыг айлган зайлуулаад пүүсний цай, бүс барааг цөлмөн авч тэмээнд ачаалан аваачсан.¹²

⁵ Эрт үеийн түшмэдийн зэрэг хэргэмийн нэрс.

⁶ Эрдэнийн чулуу, шүр, номин, лавай, болор, алт, мөнгө, шил зэргээр хийсэн малгайн сампин

⁷ Манж гүрний 10-р хааны оны цол

⁸ УА Ф1 хн 1658х351—353

⁹ УА Ф1 хн 1658х244

¹⁰ УА Ф1 хн 1658х91

¹¹ УА Ф1 хн 1658х251

¹² УА Ф1 хн 1659х70

— Мөн сард сайн ноёны гол хошууны харц ард Буяндэлгэр, Хүүхэн, Насан (эмэгтэй) нарын 30 илүү хүн царай нүүрээ бүрхэн, хар хэрээ шиг дуугаар бархиран, хүмүүсийг айлгаж, Мэнгэтийн зэрэг 5 баян айлаас 500 хиртэй хонь булаав¹³ гэжээ.

Сайн ноёны аймагт гарсан энэ хөдөлгөөний зэрэгцээгээр бас Засагт хан аймагт нутаглан байсан Барлаг өөлд, Солон Барга, Торгууд хүмүүс зэвсэглэн босч, мөн аймгийн Ачитын зэрэг 3 хошуунд дайран ороод хотонгийн босогчдын жишээгээр аль тохиолдсон феодал ноёд, чинээлэг айлын мал юмыг өдөр наранд эрээ цээргүй хураан авч их л түйвээжээ. Энэ хөдөлгөөнөөр алдагдсан мал хөрөнгийг бүртгэсэн цэсэд: «Барлаг өөлд дээрх хошуунаас тэмээ 89, морь 146, үхэр 240, хонь, ямаа 1152, эсгий, сур, хувцас, эмээл, цай, даавуу, тос будаа ба бие цагаан мөнгө 2796 лан, мөн Солон, Торгууд нар тэмээ 26, морь 73, хонь ямаа 200, цагаан мөнгө 410 ланг булаан авчээ¹⁴ гэжээ.

Халхын Их хүрэн дэх манж ноёд баруун аймгуудаар олон тооны монгол хүн хотонг дууриан хөдөлж байна гэсэн мэдээг зарим эх булгаас сонсож сэтгэл түгшиж байжээ. Гэтэл Засагт хан аймгаас Барлаг өөлд урваж, хотонтой нийлэх байдал илэрсэн тул Ховдын манж сайд яаравчлан цэрэг дайчлан татаж байна. Хэрэв Барлагууд Хотонтой нэгдвэл орон нутгийн хүрээнээс хэтэрсэн их гэгчийн хэрэг гарч болзошгүй гэсэн мэдээ ирүүлсэнд манж ноёд ардын хөдөлгөөнөөс айж цочин учиргүй уулга алдан тэр дор нь Бээжин рүү мэдүүлсэнд Ли Фаньюанаас¹⁵ уламжлан ирүүлсэн манжийн хааны зарлигт «монгол газрын муу ардууд хэрэг дэгдээсэн тул Жан-Танюд (хүрээний амбанг хэлж байна) тушааж чангаар цээрлүүлэн шийтгээд уг үндсийг устга»¹⁶ гэв. Хүрээний амбан энэ зарлигийг хүлээн аваад түүний зан омог галзуурсан бух адил мугуйд түрэмгий болж ардын хөдөлгөөнийг амь амьсгалгүй болтол баллан устгах гэж өчнөөн төчнөөн цагдаа, цэргийн ангийг зам хуваан довтолгон илгээж, бослого хөдөлгөөнд оролцсон 90 орчим ардыг барин авчруулаад хамгийн аймшигтай эрүү шүүлтээр жанчин зовоож өчиг мэдүүлэг аваад хөдөлгөөнийг толгойлсон, идэвхтэй оролцсон 20 хүний толгойг огтлоод хошуу нутагт нь аваачиж өлгөсөн ба бусдыг зовлонт ажил хийлгэхээр өмнөд хятадын үзүүр хязгаарын хол газар цөлөв. Баригдаагүй үлдсэн хань хамсаатан, салаа мөчрийг нэгд нэгэнгүй эрэн олж бүгдийг арилгахаар мөрдөлт мөшгөлт хийхийн хамт хошууны захирагч, туслагчаас эхлэн сумын занги, арван гэрийн дарга хүртэл нийт 100 гаруй тушаалтныг «хүн ардаа дарангуйлж чадаагүй» гэж торгууль оноож тэднээс бүгд 19020 лан мөнгө хураан авсан бөгөөд зарим доод тушаалтан, гар хоосон хүмүүс торгуулиас хэлтрүүлэхийг гуйсан боловч огт хэрэгсэхгүй тэдний ганц хоёр мал, өмссөн дээл, барьсан гэрийг хүртэл авах зэргээр аймаг хошуу нийтээр нь айлган сүрдүүлж байгаад ардын хөдөлгөөнийг дарж унтраав. Энэ хөдөлгөөнд бүгд 300 гаруй хүн оролцож хагас жил хиртэй үргэлжилсэн байнам. Хөдөлгөөнд оролцсон ардууд алин ч тодорхой зорилго байхгүй, хоорондоо холбоо харилцаагүй, орон нутгийн шинжтэй байсан тул манж, монголын феодал нарт хялбархан дарагджээ. Гэвч эрх чөлөөнд дуртай ард олны тэмцлийн зориг санаа мохоогүй бөгөөд ирээдүйд амжилттай тэмцэл хийхэд зарим нэгэн сургамж болсон билээ.

¹³ УА Ф1 хн 1658х251

¹⁴ УА Ф 4—26—7. 3-24-32.

¹⁵ Колоний яам

¹⁶ УА Ф1 хн 1633х67